МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2024.12.18 № 3Г-3/458

танай _____-ны №_____-т

МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ГИШҮҮН
Б.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

Хариу хүргүүлэх тухай

Танаас ирүүлсэн 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 44 тоот албан бичигтэй танилцлаа.

2003 онд батлагдсан Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилт, биелэлтийг хянан шалгах болон холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах шаардлагатай эсэх талаар танаас ирүүлсэн асуултын хариуг хүргүүлж байна.

Хавсралт .8. хуудастай.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД Т.ДОРЖХАНД

000244008173

Асуулт-1:

Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д "энэ хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах, эсхүл энэ хуулийн 51 дүгээр зүйлд заасны дагуу тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх;" гэж заасан бөгөөд хуулийн төсөл боловсруулж өргөн мэдүүлэхэд хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгаа болон хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний аль нэгийг хийх боломжтой талаар хууль тогтоомжийн тухай хууль журмаар зохицуулсан.

Энэ хүрээнд Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2019 онд боловсруулан Монгол Улсын Засгийн газраар хэлэлцүүлж, улмаар УИХ-д өргөн мэдүүлэхэд Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан бөгөөд судалгааны тайланг хавсарган хүргүүлсэн болно.

Асуулт-2:

Үндэсний бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний өрсөлдөх чадварыг сайжруулах замаар бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, сонголттой бүтээгдэхүүнээр хангах нөхцөлийг бүрдүүлэх хүрээнд хийгдсэн зарим ажлаас дурдья. Тухайлбал,

- "Ковид-19" цар тахлын дараа буюу 2022 оны хавар цементийн зарим худалдаа эрхлэгчид давамгай байдлаа ашиглан зохиомол хомстол үүсгэх замаар цементийн үнийг хөөрөгдсөнтэй холбогдуулан тус агентлагаас өргөн хүрээтэй хяналт шалгалт хийж, буруутай этгээдэд 5.4 тэрбум төгрөгийн торгууль ногдуулан хэргийг шүүхээр амжилттай шийдвэрлүүлж, импортын цементийн зохицуулалтад тодорхой санал, зөвлөмж гарган ажилласны үр дүнд стратегийн шинжтэй уг бүтээгдэхүүний зах зээлд үүсээд байсан хомстол арилж, бүтээн байгуулалтын ажлууд саадгүй хэрэгжиж сонголттой, чанартай бүтээгдэхүүнээр хангах нөхцөлийг бүрдүүлж ажилласан.

- Арилжааны банкууд иргэдэд зээл олгохдоо зээл судалсны шимтгэлийг бодит зардалтай уялдуулан тогтоох үүргээ хэрэгжүүлээгүй буюу хууль ёсны ашиг сонирхол болон хэрэглэгчийг хохироох худалдааны хууль бус арга хэрэглэсэн үндэслэлээр 2022 онд нэр бүхий 9 банканд тус бүр 20 сая төгрөгийн торгууль ногдуулсан ба хэрэг шүүхээр амжилттай шийдвэрлэгдэж, үндэсний үйлчилгээний өрсөлдөх чадварыг сайжруулж, үйлчилгээний чанар, сонголттой бүтээгдэхүүнээр хангах боломжийг бүрдүүлсэн.

- Сурагчийн дүрэмт хувцасны үнийг үгсэн тохирч худалдаалсан 3 аж ахуй эрхлэгчийг өмнөх жилийн борлуулалтын орлогын 3 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл оногдуулж, торгуулийг улсын төсөвт төвлөрүүлснээр үндэсний бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг сайжруулж, хэрэглэгчийг чанартай бүтээгдэхүүнээр хангах нөхцөл бүрдсэн.

- Стратегийн гол нэрийн бүтээгдэхүүн болох гурилын нийлүүлэлтэд тогтмол хяналт шалгалт хийж, гурилын импортын квот, татвараас чөлөөлөх бодлогын

зөвлөмж, саналыг Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын түвшинд хэлэлцүүлэн шийдвэрлүүлж ажилласан.

- Зах зээлийн шударга өрсөлдөөний нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр тодорхой салбаруудад тогтмол зах зээлийн судалгаа хийж, 2019-2024 онуудад 5 зах зээлд 5 аж ахуй эрхлэгчийг зүй ёсны монопол аж ахуй эрхлэгчээр, 39 зах зээлд 23 аж ахуй эрхлэгчийг давамгай байдалтай аж ахуй эрхлэгчээр тогтоосон байна.

- Зах зээлийн шударга өрсөлдөөний нөхцөлийг бүрдүүлэхээр 2019-2024 онуудад нийт 88 удаагийн удирдамжтай хяналт шалгалт хийгдсэн.


- 2019-2024 онуудад тендер шалгаруулалтын баримт бичигт өрсөлдөөнийг хязгаарласан талаар нийт 1525 гомдол ирүүлснийг хянасан. Үүнээс 2024 онд тендер шалгаруулалтын баримт бичигт өрсөлдөөнийг хязгаарласан талаар нийт 526 гомдол хянаснаас дотоодын давуу эрхийн зөрүү олговол зохих бүтээгдэхүүн, үйлчилгээнд давуу эрхийн зөрүү олгоогүй 43 зөрчлийг илрүүлан шийдвэрлэж, үндэсний бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлсэн.

- Ой модны сургалт, судалгааны хүрээлэнтэй хамтарсан хяналт шалгалтаар мод, зүсмэл модон материалын худалдаачид нь худалдаалж буй модны чанар /I-III зэрэглэл/-ын талаар худал мэдээлж буй зөрчлийг шалгаж, захуудын захиргаанд зөрчлийг арилгах улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж, нэр бүхий 3-н иргэнд тус тус 500,000 төгрөгийн торгууль ногдуулж, зөрчлийн үр дагаврыг арилгуулсан. Тодруулбал, барилгын тулаас, хэв хашмалд I зэрэглэлийн мод, модон материалыг ашиглах замаар аюулгүй байдлыг хангах шаардлагатай байдаг ч зэрэглэл тодорхойлох үйл явц захуудад огт хэрэгждэггүй, нэгэнт чанар буюу зэрэглэл тогтоох үйл явц хэрэгжээгүйгээс шалтгаалж хэрэглэгчдэд худал мэдээлэл өгч буй байдлыг таслан зогсоох шаардлага хүргүүлж, улмаар мод, зүсмэл модон материалын зэрэглэл тогтоох ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх, захуудад худалдаа эрхэлж буй иргэдэд мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг тогтмол зохион байгуулах шаардлагыг хүргүүлж ажилласан.


Асуулт-3:

Сүүлийн 3 жилийн байдлаар буюу 2022-2024 онд тус газрын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах, зар сурталчилгааны газарт ирүүлсэн өргөдөл, гомдлын статистик мэдээллээс харахад 2022 онд хамгийн их буюу нийт 621 гомдол ирүүлснийг салбараар нь ангилж үзвэл худалдаа үйлчилгээ, банк, санхүү, барилга орон сууцны салбарын үйл ажиллагаатай холбогдох гомдол дийлэнх хувийг эзэлж байна. Мөн тухайн онд банк бус санхүүгийн байгууллага /ломбард/-ын үйл ажиллагаатай холбоотой болон эм, эмнэлгийн үйлчилгээ, электрон тамхины зар сурталчилгаатай холбоотой өргөдөл, гомдол нилээдгүй ирсэн байна.

Зураг 1. Гомдлын статистик мэдээ



Зураг 2. Гомдлыг салбараар нь авч үзэв.



Энэ хүрээнд нийт хэрэглэгчийн эрх зөрчигдөж буй салбарт хяналт шалгалт явуулах, зөрчлийг давтан гаргуулахгүй байх, хэрэглэгчийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж хэрэгжүүлсэн зарим онцлог ажлуудаас дурдвал;

1. Монгол банкны мэдээллийн сан /хар жагсаалт/:

Иргэд, хэрэглэгчдээс ирүүлсэн "Монгол банкны Зээлийн мэдээллийн сан буюу "хар жагсаалт"-д хэрэглэгчдийн зээлийн мэдээллийг бүртгэж, үндэслэлгүйгээр санхүүгийн үйлчилгээ авах эрхийг хязгаарладаг" гэх асуудлыг хөндөж, Монгол банканд хандсан. Ингэснээр эдийн засгийн хүндрэлтэй нөхцөлд авсан зээл нь хэвийн ангиллаас буурч муу зээлийн түүхтэй болсон гэх тавин мянга гаруй хэрэглэгчийн мэдээллийг Монгол банкны Зээлийн мэдээллийн санд харагдуулахгүй байх тохируулга хийгдсэн ба дээрх хэрэглэгчдийн санхүүгийн үйлчилгээ авах боломжийг нээлттэй болгосон. Мөн Зээлийн мэдээллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай саналыг боловсруулж Монгол Улсын Шадар сайдад хүргүүлсэн.

2. Цахим орчны худалдаан дахь хэрэглэгчийн эрхийг хамгаалах асуудлаар:

Монгол Улсын хэмжээнд цахим худалдаанд тусгайлсан хууль эрх зүйн орчин байхгүй бөгөөд өнөөдрийн байдлаар цахим орчны худалдаанаас үүдэлтэй хэрэглэгчийн эрх зөрчигдсөн асуудалд Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай, Зар сурталчилгааны тухай хуулийн хүрээнд хяналт тавин ажиллаж байна. Тухайлбал,

- 2022 онд хэрэглэгчийн гомдлыг үндэслэн цахим орчинд худалдаа эрхлэгчдийн үйл ажиллагаанд 2 удаагийн удирдамжтай хяналт шалгалтыг хийж үр дүнд цахим орчинд худалдаа эрхлэгчдэд болон хэрэглэгчдэд хандсан "зөвлөмж" гаргасан бөгөөд чанаргүй, бодит байдлаас зөрүүтэй бараа худалдаалсан зөрчил үйлдсэн нэр бүхий 2 иргэнд Зөрчлийн тухай хуулиар торгууль ногдуулсан;
- ЦХХХЯ, ГХЯ болон ХХЗХ хамтарсан "Хил дамнасан болон дотоодын цахим худалдааны бодлого, зохицуулалтын асуудал, саад тотгорыг тодорхойлох" сэдэвт хэлэлцүүлэгт оролцож, "Цахим худалдааны салбар дахь хэрэглэгчийн эрх, тулгамдсан асуудал" сэдвээр мэдээлэл хийж, гадаад, дотоодын цахим худалдаа эрхлэгч аж ахуйн нэгжийн төлөөлөлтэй уулзаж, санал солилцсон;
- "Азийн хэрэглэгчийн бодлогын 9 дүгээр форум"-д цахимаар оролцож Монгол Улсад цахим зах зээл дэх арилжааны хуурамч үйлдлүүдээс хэрэглэгчийн эрхийг

хэрхэн хамгаалах талаар болон хууль эрх зүйн орчны асуудлаар мэдээлэл хийж, харилцан санал, туршлага солилцсон.

Өнөөдрийн байдлаар хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, цахим орчноор худалдаа эрхлэх үйл ажиллагааг зохицуулахаар хуулийн төсөлд нэг бүлэг болгон тусгаж өгсөн.

3. Шатахууны худалдаа эрхлэгчдийн үйл ажиллагаанд хяналт тавих хүрээнд;

- Шатахууны хязгаарлалтыг далимдуулан хүнсний бүтээгдэхүүн дагалдуулан борлуулж хэрэглэгчийг хохироох худалдааны хууль бус арга хэрэглэсэн гэх үндэслэлээр нэр бүхий 2 аж ахуй эрхлэгчид 20 сая төгрөгийн торгууль ногдуулж, хэрэг шүүхээр амжилттай шийдвэрлэгдэж, торгуулийг улсын төсөвт төвлөрүүлсэн;

- Шатахууны импортлогч болон жижиглэнгийн худалдаа эрхлэгч аж ахуй эрхлэгчдийн худалдаалж буй шатахууны найрлага, шинж чанарт мэргэжлийн байгууллагуудтай хамтран үзлэг, шалгалт хийн хэрэглэгчийн шаардлагад нийцээгүй шатахуун борлуулсан давхардсан тоогоор нийт 25 аж ахуй эрхлэгчид 225 сая төгрөгийн торгууль тус тус ногдуулсан байна;

- Стандарт хэмжилзүйн газартай хамтран шатахуун борлуулагч аж ахуй эрхлэгчдэд түгээгүүрийн дутуу шахалттай холбоотой гомдол, саналыг газар дээр нь шуурхай шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор баталгаажсан хэмжих багаж буюу мерник байрлуулах шаардлагыг хүргүүлж, гүйцэтгэлийн шалгалтаар хэрэгжилтийг нь бүрэн хангаж ажилласан. Ингэснээр хэрэглэгч шатахууны дутуу шахалттай холбоотой газар дээр нь баталгаажсан хэмжих багаж болон мэргэжлийн хүний тусламжтайгаар эргэлзээгээ арилгах, олон нийтийн хөндлөнгийн хяналтыг биечлэн хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлсэн.

4. Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ /ломбард/ эрхлэгчдийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалт:

2020 онд Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан хуулийн 14^1 дүгээр зүйлийн $14^1.1$-$14^1.5$ дахь хэсгийг хэрэгжүүлэх хүрээнд 2020-2022 онд нийслэлийн 6 дүүргийн ЗДТГ-тай хамтран нийт 180 барьцаалан зээлдүүлэх газрын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг Хүний Эрхийн Үндэсний комисс, Нийслэлийн Цагдаагийн газартай хамтран зохион байгуулсан.

Шалгалтаар хүү, алдангийн хэмжээг хууль зааснаас хэтрүүлэн тогтоосон 1 аж ахуйн нэгжид Зөрчлийн тухай хуулиар 5 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан ба зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахаар Улсын Ерөнхий байцаагчийн 24 дугаартай албан шаардлагыг хүргүүлж, биелэлтийг хангуулсан.

Түүнчлэн холбогдох стандартад нийцээгүй зөрчил гаргасан зарим ломбардын үйл ажиллагааг зогсоох саналыг нийслэлийн ЗДТГ-т хүргүүлсэн бөгөөд шалгалтын дүнг үндэслэн дүгнэлт гаргаж Монгол банк, Санхүүгийн зохицуулах хороонд мөн Мөнгөн зээлийн тухай хуулийн төсөлд санал боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлсэн. Өнөөдрийн байдлаар уг хууль батлагдаж,

барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ эрхлэгч /ломбард/-ийн үйл ажиллагаанд Санхүүгийн зохицуулах хороо хяналт тавихаар хуульчилсан байна.

5. Мод, модон материалын худалдаа эрхлэгчдийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалт:

Ой модны сургалт, судалгааны хүрээлэнтэй хамтарсан хяналт шалгалтыг хийж, улмаар мод, зүсмэл модон материалын худалдаачид нь үнэ болон хэмжих нэгж, хэмжээсийн талаар хэрэглэгчид үнэн зөв, бодит мэдээллийг өгдөггүй, стандартад заасан нэгж хэмжээсээр бүтээгдэхүүнийг худалдан борлуулаагүй зөрчил гаргасан мод, модон материалын худалдаа эрхлэгч захуудад улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлсэн бөгөөд биелэлтийг хангаж ажиллаагүй нэр бүхий 3-н иргэнд тус тус 500,000 төгрөгийн торгууль ногдуулж, зөрчлийн үр дагаврыг арилгуулсан.

Мөн хэрэглэгчийг мэдээллээр хангаж ажиллах хүрээнд мод, модон материалын хэмжих нэгж, хэмжээсийн талаарх үнэн, бодит мэдээллийг ил тод байршуулах, захын бараа бүтээгдэхүүн, худалдаа, үйлчилгээг төрөлжүүлэн ангилах байдлаар хэрэглэгч, үйлчлүүлэгчийн тав тухыг хангаж ажиллах шаардлагыг хүргүүлж, биелэлтийг хангуулсан.

6. Хими цэвэрлэгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалт:

Нийслэлийн Захирагчийн Ажлын албатай хамтран "Хими цэвэрлэгээ" эрхлэгчдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, нийт 7 аж ахуй эрхлэгчид улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж, зөрчлийг арилгуулж ажиллахын зэрэгцээ үйлчилгээ эрхлэгчдийн "Нэгдсэн сургалт" арга хэмжээг зохион байгуулж, хууль тогтоомжийн мэдлэг олгох, үйл ажиллагаандаа стандарт гэрээний нөхцөл, баталгааны хуудас, хэрэглэгчийн өргөдөл, гомдол шийдвэрлэх нийтлэг журмыг боловсруулж, батлан мөрдөж ажиллах зэрэг нэгдсэн арга зүйгээр хангаж ажилласан.

7. Сүлжээ дэлгүүр, хүнсний дэлгүүрт лангуу, кассын үнэ зөрдөг асуудлаар:

Дэлгүүрийн лангуун дээрх барааны үнэ, кассын үнэтэй зөрөх буюу бодит бус мэдээллийн улмаас хэрэглэгчид хохирол, чирэгдэл учирдаг байдлыг арилгуулах зорилгоор нийгмийн хариуцлага бүхий томоохон сүлжээ дэлгүүрүүдэд шаардлага хүргүүлсэн. Улмаар сүлжээ дэлгүүрүүд лангуу, кассын үнэ зөрсөн тохиолдолд зөрүүг газар дээр нь тооцож хэрэглэгчид олгодог байх, зориулалтын киоск төхөөрөмж, аппликэйшн ашиглан мэдээллийн зөрүүг шалгах боломжуудыг бүрдүүлж энэ ажилд Миний сүлжээ, Номин сүлжээ, И март, СиЮү, ЖиЭс 25, Абсолют, Эфэс сүлжээ, Сансар сүлжээ дэлгүүрүүд идэвхтэй, дэмжиж оролцсон байдаг.

8. Эмнэлгийн үйлчилгээ болон эм, эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн бүтээгдэхүүний зар сурталчилгаанд хийсэн хяналт шалгалт:

2021-2023 онуудад эрүүл мэндийн үйлчилгээ болон эм, биологийн идэвхт бүтээгдэхүүнийн зар сурталчилгаанд 4 удаагийн удирдамжтай хяналт шалгалт хийж, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр үр дүн амласан, хямдрал урамшуулал зарлаж үйлчлүүлэхийг уриалсан, төөрөгдүүлсэн мөн эмнэлгийн үйлчилгээ, зөвшөөрөлгүй эм, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг хууль бусаар сурталчилсан

зэрэг зөрчил гаргасан нэр бүхий 8 аж ахуйн эрхлэгчид нийт 40 сая төгрөгийн торгууль ногдуулсан.

Хяналт шалгалтын дүнг үндэслэн зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлж ажиллах "Зөвлөмж"-ийг арилжааны болон өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдэд мөн Монголын телевизүүдийн холбоо, Арилжааны телевизүүдийн холбоонд тус тус хүргүүлж ажилласан байна.

Эдгээрээс гадна олон тохиолдлыг дурдаж болох ч тус агентлагийн зүгээс аж ахуй эрхлэгчдэд хариуцлага хүлээлгэх, төрийн дарамтыг учруулах гэхээс илүүтэй зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн зөвлөн туслах, өрсөлдөөний орчин нөхцөл бүрдүүлэхэд чиглэсэн бодлогын арга хэмжээ, сурталчилгаа, нөлөөллийн ажлуудыг өргөн хүрээтэй зохион байгуулж ирсэн байдаг.

Үүний үр дүнд жил бүр тогтмол зохион байгуулагддаг уламжлал тогтсон, үр дүн нь олон нийтэд түгээгдэж байдаг тус байгууллагын нэрийн хуудас болсон олон ажлууд өнөөдөр ч ач холбогдол нь буураагүй, хэрэгжсээр байна.

Олон улсын хэрэглэгчийн эрхийг хамгаалах тэмдэглэлт өдрийг ОУ-ын байгууллагаас зарласан сэдвийн хүрээнд жил бүрийн 3 дугаар сарын 15-ны өдөр тэмдэглэн өнгөрүүлдэг. Тухайлбал,

- 2023 онд "Ухаалаг хэрэглэгч-Цэвэр эрчим хүч" нээлттэй өдөрлөгийг тус салбарын төрийн болон ТББ, аж ахуй эрхлэгчтэй хамтран зохион байгуулсан;

- 2024 онд "Хэрэглэгчийн төлөө шударга, хариуцлагатай хиймэл оюун ухаан" сэдвээр нээлттэй өдөрлөгийг улс орон даяар зохион байгуулсан;

Мөн "Хүүхэд-хэрэглэгч", "Ахмад настан-хэрэглэгч", "Цахим орчны хэрэглэгч", "Хэрэглэгчээ сонсьё", "Дэлхийн антибиотикийн эсрэг мэдээллийн долоо хоног" зэрэг аянг тогтмол зохион байгуулж хэвшээд байна.

"Хэрэглэгчийн мэдээллийн 115 төв"-ийг ажиллуулж, хэрэглэгчид анхан шатны зөвлөгөө мэдээлэл өгөх, гомдол, саналыг хүлээн авч шуурхай шийдвэрлэх зэрэг ажлуудыг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байдаг.

Асуулт-4:

Хэрэглэгчийн мэдлэг, боловсрол, хэрэглээний соёлыг дээшлүүлэх чиглэлээр жил бүр уламжлал болсон арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэхээс гадна тухайн жилийн онцлогт нийцүүлэн зохион байгуулдаг. Үүнээс 2024 оны байдлаар дараах арга хэмжээг зохион байгуулсан. Үүнд;

- Нийгмийн эрүүл мэндийн Үндэсний төвтэй хамтран "Хуванцар савны зохистой хэрэглээ" сэдвээр "Хэрэглэгчийн цаг" нэвтрүүлэг;

- ШУТИС-ийн багш, доктор, профессор А.Хүдэрийг зочноор урьж "Хиймэл оюун ухаан" сэдвээр "Хэрэглэгчийн цаг" нэвтрүүлэг;

- Нийслэлийн ЕБ-ын 50, 23-р сургуулийн сурагчдыг хамруулан "Хүүхдийн хэрэглээний мэдлэгийг дэмжих, зохисгүй хэрэглээнээс урьдчилан сэргийлэх" сэдвээр 2 удаагийн сургалт;

- "Олон Улсын хэрэглэгчийн эрхийг хамгаалах өдөр" контент - "Хэрэглэгчийн төлөө шударга, хариуцлагатай хиймэл оюун ухаан" сэдвийн хүрээнд "Алтан од-АХА" тэмцээн;

- МУИС, СУИС-ийн оюутнуудад "Хиймэл оюун ухааны бүтээгдэхүүний хэрэглээний явцад үүсч болох хэрэглэгчийн зөрчлийн эрх зүйн зохицуулалтыг хэрхэн бий болгох, баталгааны асуудал, хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай ойлголт" сэдвээр "Өдөрлөг";

- Мөн Өмнөговь аймагт "Хэрэглэгчийн төлөө шударга, хариуцлагатай хиймэл оюун ухаан" сэдэвт өдөрлөгийг зохион байгуулж, аймгийн ЕБС-ийн 120 орчим сурагчид хамрагдав;

- "ШӨХТГ нь сонгуулийн сурталчилгааны зарим хэсэгт хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлдэг" сэдвээр контент бэлтгэн хүргэсэн зэрэг болно.

Сүхбаатар, Дорнод, Төв, Өвөрхангай, Хөвсгөл, Баянхонгор, Өмнөговь, Говьсүмбэр болон Говь-Алтай, Завхан, Баян-Өлгий аймаг дахь улсын байцаагчид аймгийнхаа иргэд, хэрэглэгчдэд хууль сурталчлан таниулах сургалт явуулж, танин мэдэхүйн тэмцээн зохион байгуулах зэрэг нөлөөллийн ажлуудыг өрнүүллээ.

Монополын эсрэг газрын албан хаагчид "Монголдоо сайхан ажиллаж, амьдарья" нээлттэй өдөрлөгт оролцож, иргэд хэрэглэгчдэд байгууллагын үйл ажиллагаа, хууль тогтоомжийг сурталчлан таниулах, холбогдох асуудлаар мэдээ, мэдээлэл өгөх арга хэмжээг зохион байгуулж ажилласан байна.

Өрсөлдөөн-хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль тогтоомж болон хэрэглэгчийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, бүх нийтийн хэрэглэгчийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор бэлтгэсэн нийтлэл, нэвтрүүлэг, контент, аян болон бусад нөлөөллийн ажлууд нь олон нийтийн мэдээллийн хэрэгслээс түгээгдэхээс гадна байгууллагын албан ёсны цахим хуудас болон пэйж хуудсаар олон нийтэд хүрдэг бөгөөд тус оны хувьд ***12,650 орчим хэрэглэгчид*** хүрсэн гэсэн байна.

Асуулт-5:

Хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх асуудал нь тус агентлагийн нэн тэргүүний тулгамдсан асуудал бөгөөд үе үеийн эрхэлсэн сайд, удирдлагын түвшинд анхаарал хандуулж ирсэн байдаг. Үүнд: Орон тоог шаардлагатай хэмжээнд хүргэн нэмэгдүүлэх, түүнчлэн орон нутгийн улсын байцаагчийг орон тооны болгон ажиллуулах, хяналт шалгалтын үйл ажиллагаанд ашиглагдах тээврийн хэрэгслээр хангах, лабораторитой болгох, улсын байцаагчдын ажиллах нөхцөлийг хангахад чиглэсэн тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх зэрэг асуудлууд Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хүрээнд олон жил шийдвэрлэгдээгүй хуримтлагдсаар ирсэн байдаг.

Тухайлбал, орон тооны нэмэгдлийн асуудлын талаар;

- 2020.05.21-ний өдрийн 1/865 дугаартай албан бичгээр Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргад,

- 2020.11.11-ний өдрийн 01/1951 дугаартай албан бичгээр Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын даргад,
- 2021.03.03-ны өдрийн 01/375 дугаартай албан бичгээр Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын даргад,
- 2023.05.22-ны өдрийн 01/787 дугаартай албан бичгээр Монгол Улсын Сангийн сайдад тус тус хүргүүлж байсан байна.

2023 онд олон улсын хэрэглэгчийн эрхийг хамгаалах өдрийг угтан "өрсөлдөөн-хэрэглэгчийн эрх орон нутагт" нэгдсэн арга хэмжээг 21 аймгийн улсын байцаагчдыг хамруулан баруун, зүүн, төв, хангайн 4 бүс болгон зохион байгуулж орон нутгийн улсын байцаагчдыг чадавхжуулах сургалт, нөлөөллийн ажлыг нэгтгэн зохион байгуулсан.

2024 онд хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа албан хаагчдыг чиглүүлэх, Төрийн албан хаагчийг богино болон дунд хугацааны, мэргэшүүлэх багц сургалтад 12 улсын байцаагчийг сургасан.

Асуулт-6:

Тус газарт 2022-2024 онд буюу сүүлийн 3 жилийн байдлаар иргэдээс хэрэглэгчийн эрх зөрчигдсөн асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдлын статистик мэдээллийг дараах байдлаар харуулав.

Зураг 4.6.2. Иргэнээс ирүүлсэн өргөдөл, гомдлын статистик мэдээ

Д/д	Үзүүлэлт		2022 он	2023 он	2024 он
Нэг. Өргөдөл, гомдол					
1	Өргөдөл, гомдол		621	282	205
2	Барагдуулсан мөнгөн хохирол		734,9 сая	470 сая	210 сая
Хоёр. Хяналт шалгалт					
3	Удирдамжтай хяналт шалгалт		23	20	13
Гурав. Зөрчлийн хэрэг					
4	Зөрчлийн шинжтэй гомдол	Зөрчлийн хэрэг нээсэн	5	5	7
		Хялбаршуулан шалгасан хэрэг	8	9	2
5	Ногдуулсан торгууль		85,2 сая	41,5 сая	63,0 сая

Сүүлийн 3 жилийн байдлаар хэрэглэгчийн эрхийг хамгаалах, зар сурталчилгааны газарт хэрэглэгчдээс нийт 1,108 өргөдөл, гомдол хүлээн авч, 1 тэрбум 415 сая төгрөгийн мөнгөн хохирол барагдуулж ажилласан байна.

Хэрэглэгчийн эрх зөрчигдөж буй салбарт хяналт шалгалт явуулах, зөрчлийг давтан гаргуулахгүй байх, хэрэглэгчийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2022-2024 онд нийт 56 удаагийн хяналт шалгалтыг явуулж, Зөрчлийн тухай хуульд заасан 36 зөрчилд 189,7 сая төгрөгийн торгууль ногдуулж, хэрэг шүүхээр амжилттай шийдвэрлэгдэж, 113,1 сая төгрөг буюу 40,4 хувийн торгуулийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.